



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 1606

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс  
томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын навигацийн тоног төхөөрөмж болон шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт" Багц-1: Олон улсын шинэ нисэх буудалд ашиглагдах газрын навигацид тулгуурлан зохиосон хэрэглэлийн нислэгийн журмуудыг нислэгээр шалган баталгаажуулах шалгалтын нислэгийн үйлчилгээ үзүүлэх ИНЕГ/УТ/ТББ/Ү-04/18/1 дугаар гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

П.Гантөгс

Агаарын навигацийн бодлого,  
зохицуулалтын газрын менежер

Гишүүд :

Г.Түвшинбаяр

Нислэгийн журам боловсруулалтын  
албаны дарга

Х.Одхүү

Агаарын навигацийн бодлого,  
зохицуулалтын газрын нисэхийн  
мэдээллийн үйлчилгээний мэргэжилтэн


Ч.Болдбаатар

Худалдан авах ажиллагааны тасгийн  
ахлах инженер

С.Тамир

Үйлдвэрлэлийн нягтлан бодох  
бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын шаардлагын дагуу шалгаж хүлээн авах, гэрээний хэрэгжилтийг дүгнэн комиссын акт, холбогдох бусад материалын хамт Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээж авах Комисс /П.Гантөгс/-т үүрэг болгосугай.



Л.БЯМБАСҮРЭН

C:\My documents\TUSHAAL\2018 on\komiss tomiloh.docx

00 33